



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯНХУТАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 05 сарын 06 өдөр

Дугаар А/50

Баянхутаг сум

**ШҮЛХИЙ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЭХ ХАВРЫН ДАРХЛААЖУУЛАЛТЫН
АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ТУХАЙ**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4, 6.6, 9 дүгээр зүйлийн 9.1 - 9.9 дэх хэсэг, Мал эмнэлгийн Ерөнхий газрын даргын 2025 оны 04 дугаар сарын 18-ны өдрийн А/125 дугаар тушаал, Хэнтий аймгийн засаг даргын А/234 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх хаврын дархлаажуулалтын арга хэмжээг сумын хэмжээний бүх үхэр, гахайг хамруулан холбогдох заавар, журмын дагуу 2025 оны 04 дугаар сарын 22 -ноос 28 хоногийн хугацаанд чанартай хийж гүйцэтгэхийг "Сац манал" ХХК-ны малын эмч Н.Санжаадамба, "Унаган туур" БГБХН-ийн малын эмч Д.Цолмон, "Бумансүвд гэрэл" ХХК-ны малын эмч Х.Сүвд-Эрдэнэ, "Чандмань талын тан" ХХК-ны малын эмч Ж.Наранцэцэг, "Ханхар Их Арт" ХХК-ны малын эмч О.Эрдэнэбилэг нарт үүрэг болгосугай.

2. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилганд багийн хэмжээнд хамрагдвал зохих малыг бүрэн хамруулах, малчдад урьдчилан мэдэгдэж малыг бэлэн байлгах, тарилгын хашаа хоолойг бэлтгүүлэх ажлыг Багийн Засаг Дарга (Д.Буянбат, Д.Алтанчимэг, Б.Алтангэрэл) нарт даалгасугай

3. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгын ажлын явцад хяналт тавьж, тарилгын явцын мэдээ мэдээллийг холбогдох байгууллагад танилцуулахыг Мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч (Б.Тожилсүрэн)-д даалгасугай.

4. Захирамжын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч (С.Наранбадрал)-д даалгасугай.

ДАРГА

Д.БАЙГАЛМАА

